

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, ОНОЛЫН АСУУДЛУУД

*К.Дэмбэрэл**

Гадаадын хөрөнгө оруулалтын талаархи түгээмэл ойлголтуудын талаар энэ өгүүлэлд авч үзлээ. Гадаадын хөрөнгө оруулалтын урсгалд нөлөөлдөг үндсэн хоёр хүчин зүйлийг зохицуулалт, “гаатай орчин” хоёр хэмээн үзэж болно. “Гаатай орчин” дотор нь макро үзүүлэлт болох инфляци, ажилгүйдэл, эдийн засгийн өсөлт, экспорт гэх мэт, харин микро үзүүлэлт дотор компаний үйл ажиллагааны шинжилгээ зэргийг ойлгож болно.

Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтыг төрөөс хийнэ. Тухайлбал, 1997 онд УИХ-аас баталсан “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль” болон бусад тогтоол, зааврууд. “Хөрөнгө оруулалт” гэдэг нэр томъёог хуулиар тодорхойлж томъёолдог. Төрийн хөрөнгө оруулалтын бодлогоос “хөрөнгө оруулалт” хэмээх нэр томъёонд хамааралтай бүхий л зүйлийн утга учир хамаардаг.

“Гадаадын хөрөнгө оруулалт” гэдгийг олон улсын жишигт том утгаар нь оюуны болон эд хөрөнгийн үнэт зүйлсийг харилцан ашиг олох зорилгоор нэг улсын нутаг дэвсгэрээс нөгөө улсын нутаг дэвсгэрт оруулахыг хэлдэг.

Эдгээрээс гадна гадаадын хөрөнгө оруулалтын урсгалд нөлөөлдөг чухал зүйл бол тухайн улсын улс төр, эдийн засгийн тогтвортой байдал.

Тухайн компанийн активт хөрөнгө оруулах, аль эсвэл тухайн үйлдвэрийн хувьцааны хяналтын багцыг худалдан авахыг шууд хөрөнгө оруулалт гэнэ. Цаашдын хөгжил, өргөжилтөд нь мөнгөн хөрөнгө дутагдсан компаниуд ихэвчлэн шууд хөрөнгө оруулалтыг чухалчилдаг.

Санхүүгийн хөрөнгө оруулалт нь өнөөдөр байгаа нөөц бололцоо буюу мөнгөн хөрөнгөө өсгөх буюу ядаж хадгалж үлдэх гэсэн зорилгоор хөрөнгө оруулалт хийхийг хэлнэ.

Ямар ч хөрөнгийн олон улсын хэмжээнд хөдөлгөөнд ороход гол нөхцөл нь гэвэл:

- тухайн улсын түүхэн замнал
- тухайн улсын янз бүрийн түвшинд материаллаг хэрэгсэл, мөнгө, санхүүгийн нөөцийн хангамжийн түвшин
- үйлдвэрлэлийн туршлага
- бараа үйлдвэрлэлийн хөгжлийн болон зах зээлийн механизмын түвшин зэргийг тоочиж болно.

Олон улсын хөрөнгө оруулалт гэдэг нь өргөн утгаараа хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх оролцогчид нь дэлхийн олон орны төлөөлөл байхыг хэлнэ.

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Олон улсын хөрөнгийн хөдөлгөөнийг шинж тэмдгээр нь дараахи маягаар ангилна:

- хөрөнгийн гарал үүслээр
- хөрөнгийн ашиглах шинжээр
- хөрөнгө оруулах хугацаагаар
- хөрөнгийн зорилтот чиглэлээр

“Хөрөнгө оруулалт”-ыг хэлбэрийн хувьд зээлийн (loan, credit, capital of loan) болон бизнесийн (шууд хөрөнгө оруулалт ба өр, зээлийг худалдан авах хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх) гэж хувааж болно. Бизнесийн шууд хөрөнгө оруулалт гэдэг нь хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөндөө идэвхитэй оролцох буюу хамтарсан үйлдвэр байгуулах, тухайн улсын үйлдвэр аж ахуйн газрын хувьцааг буюу бүхлээр худалдан авах, тухайн улсад өөрийн компани аль эсвэл “охин компани”-ийг байгуулахыг хэлдэг. Өр, зээлийг худалдан авах хөрөнгө оруулалт нь share, bond, зэрэг бусад үнэт цаасийг хэлнэ. Шууд хөрөнгө оруулалтаас ялгаатай нь гэвэл тухайн хөрөнгө оруулалтыг удирдахад идэвхитэй оролцох боломж олгогдохгүй. Хөрөнгө оруулагчаас зөвхөн үнэт цаас, хувьцаа гаргасан үйлдвэр аж ахуйн газраа зөв сонгоод тодорхой тооны үнэт цаас худалдан авахыг л шаарддаг. Заримдаа дээр зааснаас өөрөөр явагдах тохиолдол ч бий. Тухайлбал, хөрөнгө оруулагч үйлдвэр аж ахуйн газрын хувьцааны хяналтын багцыг худалдан аваад удирдах үйл ажиллагаанд давамгайл эрхтэй оролцох тохиолдол бий. Ингэснээр бизнесийн бус хөрөнгө оруулалтын хэлбэр гарч ирдэг.

Гадаад орнуудад хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалт хийхдээ тухайн салбарын тухайн үйлдвэрийн бүтээгдэхүүний хэрэглэгчид буюу бүтээгдэхүүний зах зээл, тухайн үйлдвэрийн технологийн үзүүлэлт буюу уг үйлдвэрийн техникийн шинэчлэлд хэр их зардал гаргах вэ гэсэн үндсэн 2 асуудлыг л судалдаг. Монголд энэ асуудал харьцангуй өөр байгаа. Цөөн хэдэн аж ахуйн нэгжийг эс тооцвол.

1990-ээд оны өмч хувьчлалаар ажиллаж байсан үйлдвэрүүд нь зогсч үйл ажиллагааны өөр хэлбэрт шилжсэн. Хөрөнгө оруулагчид тухайн үйлдвэрт оруулсан хөрөнгө хэр ашиг олох вэ гэдгийг л харна. Хуучин технологитой, үйл ажиллагаа нь зогсч “моралийн” элэгдэлд орсон манай үйлдвэрүүдэд хөрөнгө оруулснаас бараг шинэ үйлдвэр байгуулах нь илүү хямд өртгөөр босох боломжтой хэмээн хөрөнгө оруулахаас татгалздаг тал ч бий.

Тухайн үйлдвэр аж ахуйн газарт хөрөнгө оруулахад хөрөнгө оруулалтын таатай орчны үзүүлэлтүүдийг хангах нөхцөлд шинжээчид доорхи зүйлүүдийг харгалзан үздэг.

- түүхий эдийн нийлүүлэлтийн байдал
- уг үйлдвэрийн технологийн өнөөгийн болон хэтийн төлөв байдал

- уг үйлдвэрийн хувьд импортын тоног төхөөрөмж, түүхий эдээс хэр хараат байгаа

- шинээр барилга байгууламж барих эсвэл хуучныг шинэчлэх шаардлага хэр их байгаа

- үнэлгээний үеийн үйлдвэрийн менежмент, түүний хэтийн төлөв

- үйлдвэрийн удирдлагын уян хатан байдал

- үйлдвэрийн захиргааны бодлого, үйл ажиллагаа

- үйлдвэрийн техникийн бодлого

- үйлдвэрийн өргөжилт, боловсронгуй болох бодлого

- үйлдвэрийн маркетингийн бодлого

- техникжилтийн зайлшгүй байдал

- үйлдвэрийн эргэлтэд хөрөнгө оруулалтаа нөхөх байдал

- үйлдвэрийн төлбөрийн чадвар, ашигтай байдал

- бүтээгдэхүүний нийгмийн ач холбогдол, түүний хэрэглэгчид

- тухайн үйлдвэрийн бүтээгдэхүүний улсын хэмжээнд болон олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар, олон улсын зах зээлд гарах боломж

- бүтээгдэхүүн борлуулах дилерийн идэвхи

- зах зээлийн харилцаанд соёлтой оролцдог аль эсвэл эрүүгийн

болон гэмт хэргийн шинж давамгайлсан байдал

Эдгээр үзүүлэлтээр үйлдвэр аж ахуйн газраас гадна салбарыг ерөнхийд нь дүгнэх боломжийг ч бүрдүүлдэг. Дурдсан үзүүлэлт хэдий сайн байж салбарын технологийн шинэчлэлд илүү мөнгө зарах тусам, зарсан мөнгөө илүү хурдан олж авах нөхцөл бүрдэнэ хэмээн шинжээчид үзсэн. Дээрхи үзүүлэлтийн дагуу бодит судалгааг Монголд явуулах нь зүйтэй бөгөөд хэрвээ үнэлгээ 60 ба түүнээс дээш хувьтай бол тухайн үйлдвэр, салбар олон улсын түвшинд гарах боломжтой, 50 хувьтай бол салбарын хэмжээний хөрөнгө оруулалт төдийлөн хурдан ашгаа өгөхгүй хугацаа их шаардана. Харин үзүүлэлт 50 хувиас доош бол маш их өөрчлөлт хийх шаардлагатай бөгөөд хөрөнгө оруулалт их шаардаж урт хугацаанд тэндээс ашиг харахгүй гэсэн үг.

1- р салбарт: хүнсний үйлдвэрлэл, эрчим хүчний үйлдвэрлэл, төмөр зам, иргэний нисэх, нефть олборлолт,

2-р барилга, барилгын материал үйлдвэрлэл, химийн үйлдвэрлэл

3-р уул уурхай, олборлолтын үйлдвэрлэл,

Манай хөрш ОХУ-д хөрөнгө оруулалтын бодлого, түүний мөн чанар, хэтийн төлөв ямар байгаа талаар товч өгүүлбэл. Зах зээлийн өөрчлөлтийн үйл явцад ОХУ нь өөрөө олон улсын хөрөнгө оруулалтын зах зээлийн оролцогч болон хувирсан. ОХУ-ын хувьд өнөөгийн төрийн бодлогын нэг онцлог бол гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих явдал хэмээн үзэж байгаа. Хөрөнгө

оруулалтыг үндэсний эдийн засгийн хөдөлгөгч хүч хэмээн үзэж бага биш ач холбогдол өгч байгаа.

Оросын үндэсний эдийн засгийг нь авч яваа нефть, байгалийн хийн олборлолт, хайгуул, тээвэрлэлтийн салбарт оруулах хөрөнгө оруулалт харьцангуй чамлалттай байгаа талаар шинжээчид (Сергей Караганов. ОХУ: 2020 онд., М. 2008) бичиж байгаа нь

Баялагтаа эзэн сууж, нэгдсэн байр сууриа хөрөнгө оруулагчдад илэрхийлж байсны хүчинд өнөөдөр Орос орон дэлхийн тавцанд дахин “амбицлах” чадалтай болжээ. Өнгөрсөн найман жил буюу В.Путиний засаглалын он жилүүдийг баруунд дарангуйллын өдрүүд хэмээн нэрлэдэг. Харин Оросын ард түмэн 2000-2008 оныг “хөгжлийн” гэж тодотгох нь олонтаа. Энэ жилүүдэд Оросын үндсэн орлого болох нефть, байгалийн хийн дэлхийн зах зээлийн үнэ өндөр байсан явдал дотоодын хөрөнгө оруулалтыг урагшлуулах санхүүгийн хангалттай эх үүсвэр болж чадсан.

Харин Монгол Улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалт ороход анхаарах онцлог талууд бий.

- дотоод зах зээл бага
- дэд бүтцийн хөгжил сул
- дотоодын хөрөнгө оруулалт хийх санхүүгийн чадавхи сул
- түүхий эдийн экспорт зонхилдог
- мэргэжилтэй боловсон хүчин дутагдалтай
- бусад

Гадаадын хөрөнгө оруулалт татахад бид өөрийн давуу талыг бодитоор л авч үзэх ёстой. Монгол орон алт, зэс, уран, нүүрс, молибден, фосфор болон бусад байгалийн арвин их баялагтай, байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж болох газар тариалангийн 1.3 сая гектар талбайтай, 42 сая толгой малтай.

Монгол Улс нь Ази, Европын геостратегийн уулзварт оршдогийн хувьд бүс нутгийн эдийн засгийн бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан төсөл, хөтөлбөр, тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх, бүс нутгийн эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд анхаарвал илүү.

Орос, Хятадаас илүү давуу нөхцөл бүрдүүлж байж манайд оруулсан мөнгө Хятад, Оросын зах зээлд гарч илүү ашиг олох нөхцлийг хөрөнгө оруулагчид өгнө гэсэн үг.

Улс орны эдийн засгийн өсөлт, хөгжил нь гадаадын хөрөнгийн урсгалыг Монгол руу хандах нэг гол нөхцөл болох ба тэр урсгалыг улс оронд ашигтай байх хувилбараар зохицуулах үндэсний боловсон хүчин ч чухал.

Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль болон бусад хууль,

тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан байдаг. Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглох, гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад монголын хөрөнгө оруулагчдад олгогдоос дутуугүй тааламжтай нөхцөл олгодог. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу дэд бүтэц, боловсруулах, экспортын чиглэлтэй үйлдвэрлэл эрхэлж байгаа хөрөнгө оруулагчдад орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгож, технологийн зориулалтаар ашиглах тоног төхөөрөмжийг импортлоход гаалийн ба НӨАТ-ийн чөлөөлөлт олгож байгаа.

Улсын Их Хурлаас улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажлын байр шинээр бий болгох, албан бус эдийн засгийг бууруулах, хөрөнгө оруулалтын орчинг олон улсын жишигт ойртуулах зорилгоор татварын багц хуулиудын 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн. Аж ахуйн нэгж, байгууллагын албан татварын хувь хэмжээ тус бүр 5 пунктээр буурч, 10% болсон нь хөрөнгө оруулагчдад томоохон хөнгөлөлт болсон гэж үзэж байна.

Томоохон хөрөнгө оруулалтын хувьд гадаадын хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран Монгол Улсын Засгийн газартай тодорхой хугацаанд “Хөрөнгө оруулалтын гэрээ” байгуулах хүсэлт тавьж болох бөгөөд энэхүү гэрээ нь бизнесийн тогтвортой үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн баталгаа болно.

Европын Холбооны зах зээлд 7200 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг импортын тэг тарифтай оруулах GSP+ нөхцөлд Монгол Улсыг хамруулсан нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар худалдааны энэхүү тааламжтай нөхцлийг харилцан ашигтай хэрэглэх бололцоо олгож байна.

Монгол Улсын Засгийн газар нь “Давхар татвараас чөлөөлөх тухай” хэлэлцээрийг 33 улстай, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-ийг 39 улстай байгуулсан ба “Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай” 1965 оны Вашингтоны конвенцид 1996 онд, “Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай” 1985 оны Сөүлийн конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон.

Түүнчлэн Монгол Улс нь Дэлхийн банкны Хөрөнгө оруулалтын олон талт даатгалын агентлагийн /MIGA/ гишүүн бөгөөд хөрөнгө оруулагчид MIGA-гийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй.

Монгол Улсын төр засаг эдгээр эрх зүйн тааламжтай орчинг бүрдүүлснийг олон улсын байгуулагууд давхар баталж өгсөн. Тухайлбал, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-аас

дэлхийн 140 орны гадаадын хөрөнгө оруулалт шингээх чадварыг үнэлэхэд Монгол Улс энэ үзүүлэлтээр харьцангуй их хөрөнгө оруулалт татаж чадсан, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах харьцангуй өндөр чадавхитай орнуудын жагсаалтанд багтах болсон. Манай орны зээлдэх зэрэглэлийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн Фич, Мүүдиз, Стандарт энд Гүэрс байгууллагууд В+ хэмээн тогтоосон.

ДХБ-аас манай улсын худалдааны бодлогыг 2005 онд хянаад Монгол Улсын эдийн засгийн өсөлт нь тогтвортой, инфляцийн боломжийн түвшинд байна гэж дүгнэсэн. Дэлхийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпорацитай хамтарч 175 улс орны бизнес эрхлэх хууль тогтоомжид хийсэн Doing Business 2007 судалгаагаар манай улс бизнес эрхлэхэд хүндрэл багатай орнуудын эхний 45-д бичигдсэн байна.

Монгол Улсад орох гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ жил тутам нэмэгдэж өссөн дүнгээр 1.6 тэрбум ам.долларт хүрсэн байна. 1995-96 оны түвшинд жилдээ 30-40 сая орчим ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт бүртгэгдэж байсан бол 2007 он гэхэд жилд 300 саяас дээш ам.долларын хөрөнгө оруулалт орох болсон байна. Тухайлбал, 2005 онд 311 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. 2007 оны байдлаар 1990 оноос хойш дэлхийн 96 орны 5777 гадаадын хөрөнгө оруулалттай компани Монголд бүртгүүлсний 80 шахам хувь нь зөвхөн 2000-2005 онуудад хийгдсэн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаар авч үзвэл геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт ГШХО-ын 43,8 хувь, хөнгөн үйлдвэрт 5,6%, банк санхүүгийн үйл ажиллагаанд 5,5%, барилгын үйлдвэрлэлд 3,5%, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтанд 5,5%, үлдэх хувь нь худалдаа, үйлчилгээний болон бусад салбарт орсон байна.

Хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ, Канад, БНСУ, АНУ, Япон, ОХУ, Их Британи Умард Ирландын хөрөнгө оруулагчид эхний байруудад байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын 95 хувь нь Улаанбаатар хотод, орон нутагт таван хувь нь ногдож байгаа аж. Зөвхөн 2006 онд хийсэн хөрөнгө оруулалтын 33 хувь нь Хятадынх, нэг хүрэхгүй хувь нь Оросынх байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд “Гадаадын хөрөнгө оруулагчийн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 2.0-10.0 сая ам. доллар буюу түүнтэй тэнцэх төгрөг байхаар бол тогтвортой байдлын гэрээг 10 жил, 10.0 сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байхаар бол 15 жилээр тус тус байгуулна” хэмээн заасан.

Гадаадын хөрөнгө оруулах үйл явцад монголчууд өөрийн үнэлэмжийг маш зөв тогтоох ёстой. Бүр илүү судлаж, харьцуулж байж

шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэмжийг бий болгох, өөрийн эрх ашгийг илүү харах нь зүйтэй. Гадаадын хөрөнгө оруулалтаар Монгол Улсад зөв зохистой менежмент, технологийг “суурьшуулах” нь чухал. Өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд 7700 гаруй байгаа гэсэн дүн бүртгэл бий.

Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт нээлттэй орны эдийн засгийн өсөлт бусдаас хоёр дахин илүү байдаг гэсэн судалгаа ч бий.

Эдийн засгийн эрчимтэй бөгөөд тогтвортой өсөлтийг хангах, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт дэвшилтэт технологи, үйл ажиллагааны шинэ ур чадвар, арга барилыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, улмаар ажлын байр шинээр бий болгох, экспортын баримжаатай, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийг хөгжүүлж, олон улсын зах зээлд өрсөлдөж чадахуйц нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд “Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын үндсэн зорилго чиглэгдэж байна” хэмээн төр засаг томъёолж ирсэн.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого нь гадаадын хөрөнгө оруулагчдад татварын болон бусад хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, тэдгээрийн хөрөнгө өмчлөх эрх, хөрөнгө оруулалтыг хамгаалах хууль зүйн баталгааг хэрэгжүүлэх, захиргааны илүү олон шат дамжлага, саад тогтвор, хүнд суртлыг арилгахад оршиж байна.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу гадаадын хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэл, үйлчилгээний бараг бүх салбарт болон Монгол Улсын нутаг дэвсгэрийн аль ч хэсэгт оруулахыг зөвшөөрдөг. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулагчдыг ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын хөрөнгө оруулагчидтай адилтган ижил нөхцөлтэйгээр авч үздэг.

Сингапурчууд “нэг үндэстний эрх ашгийг хэзээ ч хамгаалдаггүй, олон орны зах зээл дээр зэрэг ажилладаг гэдэг утгаараа гаргасан бүтээгдэхүүнийхээ борлуулах арга замыг давхар шийдчихсэн байдаг, хамгийн гол нь жижиг, буурай орны ашиг сонирхлыг хөндөхгүй байх, нэг орны ноёлсон бодлогод автахгүй гээд давуу талтай” (“Зууны мэдээ” Д.Отгонбаяр) гэдгийг олж харсан. Монголчууд үүрэн телефоны “Скайтел” компанитай байгуулсан гэрээг эс тооцвол бараг бүх хөрөнгө оруулалтын гэрээг ашигт малтмалын салбарт байгуулж байжээ.

Тогтвортой байдлын гэрээ нь Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын хууль, Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагддаг бөгөөд татвараас чөлөөлдөг хөнгөлөлт үзүүлдэг гэрээ биш, гагцхүү хуулийн дагуу олгосон эрх үүргийг тогтворжуулдаг гэрээ юм.

Энэ гэрээний дагуу авто зам, замын байгууллагуудаас бусад аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортлож байвал тухайн аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас эхний гурван жилд бүрэн чөлөөлж дараагийн гурван жилд 50 хувь хөнгөлнө гэсэн бол 2000 оны арваннэгдүгээр сард татварын хуулинд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр үнэт металлаас бусад эрдсийн түүхий эд нефть хатуу түлш олборлох, боловсруулах, металлург, хими төмөрлөг, машины үйлдвэр электроникийн салбарт таван жилийн хугацаанд чөлөөлж дараагийн таван жилд 50 хувь хөнгөлнө гэж заажээ.

Дүгнэлт:

1. Гадаадын хөрөнгө оруулалттай компани илүү “төлөх ёстой” гэсэн зүй бус хандлага манайд байгааг “хуулийн дагуу төлөх ёстой” гэсэн горимд оруулах
2. Хөрөнгө оруулагчдад боловсон хүчин сургах, шинэ менежмент, технологи бий болгох шаардлага нэн тэргүүнд байх
3. Хууль, эрх зүйн орчин тогтвортой байлгаж, хоорондын зөрчлийг арилган бүгд эрх тэгш дагаж мөрддөг байх
4. Гадаадын хөрөнгө оруулагчдад үйлчлэх төрийн төв байгууллагын ажилтнуудын ёс зүй, мэдлэг чадварыг өндөржүүлэх
5. “Шаардлага султай” улсыг хөрөнгө оруулагч сонирхдог. Тиймээс зарим хөрөнгө оруулагч өндөр болзлоос “зугтаж”, аль болох эрх зүйн орчин муу, хязгаарлалт багатай орныг сонирхдог нь нууц биш.
6. Бид хөрөнгө оруулалт гээд яриад байдаг, харин ямар үйлдвэр, аж ахуйд оруулах талаар тодорхой зүйл байдаггүй учраас ХО гэдэг нь нэр томъёоноос цаашгүй зүйл байгаа. Хөрөнгө оруулалтыг тун төвөгтэй болсон салбарт л төр хүсдэг болохоос түүнээс биш “зүгээр л ашиг олчихоор” тийм салбарт бол “эрх ямбыг” хязгаарлах ёстой.
7. Зах зээлд эрэлт ихтэй хурдан борлогддог, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр л хөрөнгө оруулалт татах боломжтой.
8. Манай үйлдвэрүүдийн хувьцаа худалдан авах хөрөнгө оруулалтын хэлбэр эхэлж байгаатай холбоотойгоор татвар, ашиг, хөрөнгө хөрвүүлэх, шилжүүлэх асуудлыг олон улсын жишигт нийцүүлэх
9. Тогтвортой байдлын гэрээнд анхаарах зүйлд:
 - а. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гэдэг ойлголтыг тодорхой болгох
 - б. Тийм хугацаанд тийм төгрөгийн хөрөнгө оруулна гэдэгт үл хууртах

Эцэст нь хэлэхэд, Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрлэл, байгалийн баялаг ашиглахтай холбоотой хөрөнгө оруулагчдад тодорхой нөхцлүүдийг дагаж мөрдөх шаардлага тавигддаг. Харин түүнийг ёсчлон биелүүлэх нь хөрөнгө оруулагчийн үүрэг бөгөөд тэд үйл ажиллагаатайгаа холбоотой мэдээ мэдээллийг дэлгэх ёстой байдаг.

Ашигласан ном зохиолууд

1. Аксенова Н.И. Иностранные инвестиции: Учеб.-метод.комплекс для студентов. – Новосибирск., 2006. – 92 с.
2. Костюнина Г.М. Международная практика регулирования иностранных инвестиций: Учеб. пособие /Г.М.
3. Черкасов В.Е. Международные инвестиции. Учебно-практическое пособие. М.: Дело, 1999. – 160 с.
4. Гнилитская Е.В. Теоретико-методологические основы иностранного инвестирования отечественного производства. - М., 2001.- 51 с.
5. Киреева А.В. Некоторые аспекты государственного регулирования иностранных инвестиций в России. - М.: МАКС Пресс, 2000.- 26 с.
6. Киринов А.В. Регулирование иностранных инвестиций в экономически развитых странах . - М.: Изд-во МГУ, 2001.- 71 с.
7. Матяш В.Н. Привлечение иностранных инвестиций - стратегия России в XXI столетии и позиция Запада: Учеб. пособие /В.Н. Матяш; Дипломат. акад. МИД России. Ин-т актуал. междунар. пробл. - М., 2001.- 118 с.
8. Мельников А.Б. Проблемы воздействия иностранных капиталов на экономическую безопасность российских регионов /А.Б. Мельников. - Краснодар, 2001.- 243 с.
9. Филев А.А. Реализация инвестиционных проектов Всемирного банка в России /А.А. Филев. - М.: МАКС Пресс, 2002.- 42 с.
10. Вознесенская Н.Н. Иностранные инвестиции: Россия и мировой опыт. М. Инфра-М, 2002. 213 с. 65.5 М 433
11. З.Бороо. Гадаадын шууд хөрөнгө оруулалт. УБ., 2004 он.
12. А.Шагдарсүрэн. Хөрөнгө оруулалтын эдийн засгийн асуудалд. УБ., 2005 он.
13. The WORLD BANK . Technology, adaptation and exports., 2006
14. Franklin R.Root . International Trade and Investment., 7th edition , 1994
15. <http://www.ivr.ru>
16. <http://www.allinvestrus.com>
17. <http://www.investmentrussia.ru>
18. <http://www.rosleasing.ru>
19. <http://www.leasing.ru>
20. <http://www.invest.rin.ru/>